

# Гэм нүгэл үйлдсэн хүмүүсийг уучлах

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Коринтчуудын нэгэн адилаар, танай тойргийн хүмүүс гэм нүгэл үйлдсэн хүмүүст өгөх хайр, уучлалаа нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж төсөөл. Энэ шалтгаанаар танай бишоп таныг хичээлийн эсвэл чуулгын уулзалтын эхэнд уучлалын талаар бодол санаагаа товчхон хуваалцахад урьсан байна. Хэдэн минут зарцуулаад, хэлэх үгийнхээ тоймыг гарга. Дараах зүйлсийг оруулсан байхад анхаар.

1. Коринт 2:7–11-ээс дор хаяж нэг шүлэг эсвэл хэллэг.
2. Өөр нэг судар эсвэл Сүмийн удирдагчийн гаргасан мэдэгдэл. (Та ахлагч Дунканы доорх мэдэгдлийг эсвэл түүний дурдсан аль нэгэн судрыг ашиглаж болно.)
3. Бусдад хайр, өршөөл үзүүлэх тухай мөн энэ нь хэрхэн бидэнд Аврагчтай илүү ойртоход тусалдаг талаарх өөрийн бодол санаа, гэрчлэл.

## Уучлалын талаарх сургаал

Далын ахлагч Кэвин Р.Дункан ийн хэлсэн.



Бидний ихэнх нь уучлахыг хүсдэг боловч уучлахад маш хэцүү гэж боддог гэдэгт би итгэл дүүрэн байна. Бидэнд шударга бус явдал тохиолдох үед тэр даруй “Тэр хүн буруу зүйл хийсэн. Тэр шийтгэлээ хүртэх ёстой. Шударга ёс хаана байна вэ?” гэж хэлж ч магадгүй. Хэрэв уучлах юм бол шударга ёсны хууль үйлчлэхгүй, шийтгэл оногдохгүй гэж бид бас буруу боддог.

Энэ бол буруу юм. Нигүүлсэл шударга ёсыг дээрэмдэж чадахгүй (Алма 42:25-ыг үзнэ үү) учраас Бурхан тохирох шийтгэлийг оноох болно. Бурхан та бидэнд хайраар “Шүүлтийг зөвхөн надад үлдээгтүн, учир нь энэ нь минийх бөгөөд би хариуг нь төлөх болно. Амар амгалан та нарт байг” [Сургаал ба Гэрээ 82:23] хэмээн амласан билээ. (Кэвин Р.Дункан, “Өршөөлийн эдгээх тос,” *Ensign*, May 2016, 33–34 эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 17–19)

- Матай 5:43–44
- Ефес 4:32